

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2015 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Оюунгэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр гишүүдийн олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг томъёоллыг төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг бэлтгэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үеэр Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Я.Содбаатар нар хуулийн төслийн 3.1.4 дэх заалтын ““Хүүхэд харах явуулын үйлчилгээ” гэж” гэсний дараа “хот, суурин газраас бусад газарт” гэж нэмэх, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, С.Эрдэнэ нар хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх зэрэг зарчмын зөрүүтэй санал гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.2.3-т зааснаар дахин санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг болон Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгийн үеэр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусгасан төслийн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан болно.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн, хуулийн төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Д.БАТЦОГТ**

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын  
хороо дэмжсэн санал:**

1.Төслийн 3.1.4 дэх заалтын ““хүүхэд харах явуулын үйлчилгээ” гэж” гэсний  
дараа “хот, суурин газраас бусад газарт” гэж нэмэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Я.Содбаатар**

2.Хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, С.Эрдэнэ**

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО**

---oOo---